



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 11313

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Олон Улсын Ахмадын баярыг тохиолдуулан аймгийн Ахмадын урлагийн V бага наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд: М.Болор-Эрдэнэ	Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Доржсүрэн	ТХДЖТ-ын дарга
Г.Цэрэндорж	Аймгийн Ахмадын хорооны дарга
А.Ууганбаяр	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын захирал

Нарийн бичгийн дарга: Х.Цогзолмаа БСУГ-ын мэргэжилтэн

Хоёр. Бага наадмын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Ахмадын урлагийн V бага наадмын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулан, 10 сарын 25-ны дотор багтаан тайлагнахыг ажлын хэсэг /А.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200885